



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 95 өдөр

Дугаар 1385

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.4.2, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрийн 3.2.4.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлсэн “Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ техник, технологийг нутагшуулах нь” төслийн дэмжлэгтэйгээр нэвтрүүлсэн зайн оношилгоо, эмчилгээний чиглэлээр зөвлөгөө өгөх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр лавлагаа төвөөс эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх журам”-ыг нэгдүгээр, “Цахим зөвлөгөө авахад хөтлөх маягт”-ын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цахим зөвлөгөө, сургалтын явцын найдвартай, аюулгүй, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Баянжаргал/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/ нарт даалгасугай.


3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгсөн эмч, эмнэлгийн мэргэжилтний зөвлөгөө өгсөн цаг, сэдэв, зөвлөгөөний үр дүнг үндэслэн улирал бүрт тооцож, тухайн эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны сургалтын багц цагт оруулан тооцож ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/ нарт даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, дэд бүтцийн бэлэн байдлыг хангаж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, мэдээллийн урсгал, интернетийн хурдыг нэмэгдүүлэх, шаардагдах санхүүжилтыг жил бүрийн батлагдсан төсөвт багтаан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар /Г.Эрдэмбилэг/, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081465

Эрүүл мэндийн сайдын 2019 оны ...⁰⁸
дугаар сарын 14. өдрийн 11. тушаалын
нэгдүгээр хавсралт
1385

**ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЛАВЛАГАА ТӨВӨӨС
ЦАХИМААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эх, хүүхдэд эрүүл мэндийн тусlamжийг зайнаас тэгш хүrtээмжтэй, шуурхай, хугацаа алдахгүй үзүүлэх зорилготой.

1.2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр тусlamж үйлчилгээ үзүүлдэг амаржих газар, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношилгоо эмчилгээний төв болон бусад эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөгөө өгөхөд мөрдөнө.

1.3. “Байгууллагын нууцын тухай” хууль, “Хувь хүний нууцын тухай” хууль, “Цахим мэдээллийн нууцын тухай” хууль ба холбогдох бусад хууль, журам, зааврыг чанд мөрдөж, хувь хүний нууцыг хамгаална.

1.4. Зөвлөгөө авахад үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авсан байна. Хэрвээ үйлчлүүлэгч ухаангүй, өөрөө бие даан шийдвэр гаргах чадваргүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрлийг бичгээр авна.

1.5. Цахим зөвлөгөө нь яаралтай (24 цагийн дотор) болон төлөвлөгөөт бус (1-3 өдрийн дотор) гэсэн 2 үндсэн хэлбэртэй байна.

1.6. Ажлын цагаар зөвлөгөө авах бол тусlamж үйлчилгээний зохицуулагч төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч, ажлын бус цагаар ахлах жижүүрийн ахлах эмч цахим зөвлөгөө авах, өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.7. Цахим зөвлөгөөг ажлын цагаар холбогдох мэргэжлийн зөвлөх эмч, тасгийн эрхлэгч өгнө. Ажлын бус цагаар зөвлөгөөг тухайн жижүүрийн баг өгнө. Шаардлагатай бол бусад мэргэжлийн эмчийг дуудаж зөвлөгөөнд оролцуулна.

1.8. Яаралтай бус тохиолдолд зөвлөгөө авахдаа Mn obstetric программ хангамжийг ашиглана.

1.9. Зөвлөгөө авах өвчтөний мэдээлэл оруулсан талаар зөвлөгөө өгөх эмчийн цахим шуудангийн хаягаар анхааруулах зурvas ирж байхаар зохицуулна.

1.10. Зөвлөгөөний үед зөвлөх эмч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдэж буй эмнэлзүйн заавар стандартын дагуу зөвлөгөөг өгөх бөгөөд цахим болон бичгээр илгээнэ.

1.11. Зөвлөгөө авсан эмч зөвлөх эмчийн өгсөн зөвлөмжийг хувилан авч, үйлчлүүлэгчийн өвчний/ төрөлтийн түүхэнд хавсаргана.

1.12. Зөвлөгөө авсан болон өгсөн талаарх мэдээллийг өдөр тутмын жижүүрийн мэдээнд мэдээнлэ.

1.13. Зөвлөгөө авах, өгөх талууд тухайн асуулт, танилцуулга дууссан дохиогоо тухай бүрт нь мэдэгдэнэ.

1.14. Цахим зөвлөгөөний явцыг хадгалж, сургалт, эмнэлзүйн хурал зөвлөгөөн хэлэлцүүлэгт ашиглахыг зөвшөөрне.

1.15. Хуулийн баримтаар ашиглахыг хориглоно.

1.16. Энэхүү зөвлөгөө нь эмчээс эмчид өгөх мэргэжлийн болон арга зүйн зөвлөн туслах үйл ажиллагаа бөгөөд шийдвэрийг тасгийн эмч, хэвтэн эмчлүүлж буй эмнэлгийн ерөнхий эмч, тасгийн эрхлэгч хариуцна.

Хоёр.Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр зөвлөгөө өгөх байгууллагын зохицуулагчийн үүрэг.

2.1. Ажлын цагаар зөвлөгөө авахаар оруулсан мэдээллийг хүлээн авч, бүртгэн, эмчилгээ эрхэлсэн дэд захиралд танилцуулан, хуваарьт эмчээр зөвлөгөө өгүүлнэ.

2.2. Зөвлөгөөг шуурхай, хугацаа алдахгүй, чанартай үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3. Зөвлөгөөний явцад хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн, тохиолдол бүрт өгсөн зөвлөгөө, зөвлөгөөний шийдвэрийг цахимд байршуулна.

2.4. Зөвлөгөөний тайлан мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, эмнэлгийн статистик бүртгэл мэдээллийн албанад мэдээлнэ.

2.5. Зөвлөгөө өгөх өрөөний тоног төхөөрөмжийг цахим зөвлөгөө өгөх өрөө тасалгааг хариуцсан тасгийн тухайн өдрийн ээлжийн жижүүр сувилагчид хүлээлгэн өгч, хүлээн авч, гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.6. Цахим зөвлөгөө өгөх өрөө тасалгааны тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, засвар үйлчилгээг хугацаанд нь тогтмол хийлгэж, баталгаажуулан, тэмдэглэл хөтөлнө.

2.7. Зөвлөгөө авч байгаа байгууллагаас суралцаж дадлагажиж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг зөвлөгөөний үед байлцуулна.

Гурав.Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр зөвлөгөө авах байгууллагын зохицуулагчийн үүрэг.

3.1. Ажлын цагаар зөвлөгөө авах тухай мэдээллийг эмчилгээ эрхэлсэн дэд захиралд танилцуулан, эмчлэгч эмч нарыг байлцуулан, үйлчлүүлэгчийн биеийн байдал, хийгдсэн шинжилгээ, онош, авсан арга хэмжээний талаарх мэдээлийг танилцуулах эмч(эмчлэгч эмч)-ийг томилон зөвлөгөөг авна.

3.2. Зөвлөгөөг шуурхай, хугацаа алдахгүй, чанартай авахад дэмжлэг үзүүлнэ.

3.3. Зөвлөгөөний явцад хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн, тохиолдол бүрт цахим зөвлөгөөний шийдвэрийг цахимд байршуулна.

3.4. Зөвлөгөө авсан тухай тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, статистик бүртгэл мэдээллийн албанад мэдээлнэ. Зөвлөгөөний бүртгэлийн журналтай байна.

3.5. Зөвлөгөө авах өрөөний тоног төхөөрөмжийг цахим зөвлөгөө авах өрөө тасалгааг хариуцсан тасгийн тухайн өдрийн ээлжийн жижүүр сувилагчид хүлээлгэн өгч, хүлээн авч, гарын үсгээр баталгаажуулсан байна.

3.6. Цахим зөвлөгөө авах өрөө тасалгааны тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, аюулгүй ажиллагааны засвар үйлчилгээг хугацаанд нь тогтмол хийлгэж, баталгаажуулан, тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай тохиолдолд мэдээлэл, технологийн мэргэжилтэнг байлцуулна.

Дөрөв. Зөвлөгөө авахаар оруулах мэдээллийн шаардлага

4.1. Зөвлөгөө авах эмч нар хоорондоо зөвлөлдөж, тохиолдлын мэдээллийг товч тодорхой, оновчтой бичиж, хийгдсэн шинжилгээ, дүрс оношилгооны зургийн мэдээллийг боломжтой программуудыг ашиглан зөвлөгөө өгөх талд дамжуулна.

4.2. Зөвлөгөө авах гэж буй зорилгоо тодорхой бичнэ. Тухайлбал: онош тодруулах, шинжилгээний онцлог, эмийн ба мэс засал эмчилгээ, төрөлт шийдэх аргыг сонгох эсвэл дээд шатлалын аль нэг эмнэлэгт шилжүүлэх ... гэх мэт

4.3. Зөвлөгөө өгсөн эмчийн зөвлөгөөг баримтжуулж, үйлчлүүлэгчийн өвчний/төрөлтийн түүхэнд хавсаргана. Энэ тохиолдолд баталгаажсан гарын үсэгний цахим хэлбэрийг ашиглахыг зөвшөөрнө.

4.4. Зөвлөгөөний дагуу оношилж, эмчилсэн үр дүнг зөвлөгөө авсан багийнхан эргэн мэдээлж сүлжээнд бичиж эргэх холбоотой байна.

4.5. Цахим зөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчийг яаралтай шилжүүлэх бол лавлагаа төвийн захирал, эмчилгээ эрхэлсэн дэд захирал нарт зөвлөгөө өгсөн баг утсаар мэдэгдэнэ.

Тав. Зөвлөгөө өгөх баг, эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг.

5.1. Ирсэн мэдээллийн дагуу мэргэжлийн зөвлөгөөг батлагдсан заавар, журам, стандартын дагуу, нотолгоонд тулгуурлан өгнө.

5.2. Зөвлөгөө өгсөн талаарх мэдээллийг өдөр тутмын жижүүрийн мэдээнд оруулж мэдээлнэ.

5.3. Эх, нярай эндсэн болон ноцтой хүндрэл бүртгэгдсэн тохиолдолд авах хариу аргахэмжээний талаар зөвлөгөөг шуурхай өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Зургаа. Цахим зөвлөгөө өгөхөд баримтлах зарчим.

6.1. Зөвлөгөө өгөх болон авах эмч нар үйлчлүүлэгчтэй мэндэлж, өөрсдийгөө танилцуулна.

6.2. Эмч- эмч, эмч- эмнэлгийн мэргэжилтэн, эмч-үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээг баримталж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.

6.3. Үйлчлүүлэгчид сонсгох шаардлагагүй мэдээллийг үйлчлүүлэгчид чихэвчээр дуу сонсгох зэргээр түүний анхаарлыг өөр зүйлд чиглүүлсэний дараа асууж тодруулж, ярилцана.

6.4. Үйлчлүүлэгчээс өвчний тадаарх зохих мэдээллийг авсны дараа үйлчлүүлэгчид түргэн эдгэхийг хүсэж, түүнийг эмчилж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сайшааж, талархал илэрхийлэх зэргээр үйлчлүүлэгчийг зоригжуулна. Дараа нь үйлчлүүлэгчийг өрөөндөө орж амрах хэрэгтэй гэж зөвлөн цахим зөвлөгөө явагдаж буй өрөөнөөс шилжүүлнэ.

6.5. Цахим зөвлөгөөний явцад хориглох зүйлс:

6.5.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн болон ёс зүйн алдааны талаар шууд нээлттэй хэлэлцэх,

6.5.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний загнах, доромжлох,

6.5.3. Үйлчлүүлэгчийн дэргэд оношилгоо эмчилгээнд тулгарсан бэрхшээл, саад, алдааг хэлэлцэх,

6.5.4. Тухайн тохиолдолд зөвлөгөө авах явцад дундуур нь өөр тохиолдлыг зэрэгцүүлэн ярьж зөвлөгөө авах,

6.5.5. Тухайн зөвлөгөөнөөс өөр хувийн чанартай яриа өрнүүлэх, ямар нэгэн зүйл нэхэх, шаардах.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08
дугаар сарын 15. өдрийн 11. тушаалын
хоёрдугаар хавсралт 1385

ЦАХИМ ЗӨВЛӨГӨӨ АВАХАД ХӨТЛӨХ МАЯГТ

Он сар өдөр цаг минут....
Эмнэлгийн нэр
Өвчтөний овог, нэр
Үндсэн онош

Зөвлөгөө авсан эмч

нар.....

Зөвлөгөө өгсөн эмч

нар.....

1. Үйлчлүүлэгчийн мэдээллээс тодруулсан нэмэлт асуулт:

.....
.....
.....
.....
.....

2. Үйлчлүүлэгчийн бодит байдалд өгсөн дүгнэлт:

.....
.....
.....
.....
.....

3. Шинжилгээний хариунд өгсөн дүгнэлт ба зөвлөсөн нэмэлт шинжилгээ

.....
.....
.....
.....
.....

4. Оношийн талаар өгсөн санал

.....
.....
.....
.....
.....

5. Эмчилгээнд өгсөн санал

.....
.....
.....
.....
.....